

МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 08 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө, журам, зөвлөмж, загвар батлах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.6 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрдугаар зүйлийн 2.9, Үндэсний зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023 он/-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г нэгдүгээр хавсралтаар, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийг гуравдугаар хавсралтаар, Үндэсний зөвлөлийн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, салбар хоорондын ажлын уялдааг хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албанд тус тус даалгасугай.


3. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаад дотоодын болон аж ахуйн нэгж, байгууллагын тусламж, зээлийн хөрөнгөөр холбогдох хуулийн хүрээнд санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Үндэсний зөвлөлийн нийт гишүүд, нийслэл, аймаг орон нутгийн салбар зөвлөл, Засаг дарга нарт даалгасугай.

4. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ыг хэрэгжүүлж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллахыг Үндэсний зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

5. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа батлуулж, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр Үндэсний зөвлөлийн Ажлын албанд ирүүлж ажиллахыг орон нутгийн салбар зөвлөлд даалгасугай.

6. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023 он/-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийн биелэлтийг хагас, бүтэн жилээр Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Б.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд,
Үндэсний зөвлөлийн дарга



УХҮРЭЛСҮХ